



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/86


Сүхбаатар сум

Коронавируст халдвар / covid-19/-ын үед  
тусгаарлах, ажиглалтын түр байранд байрлах  
иргэдийн нэг өдрийн зардлын хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 63 дугаар зүйлийн 63.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай" 02 дугаар тогтоолын 3 дахь заалт, Улсын Онцгой комиссын 07 дугаар хуралдааны тэмдэглэлийн 9.3 дахь заалт, Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн "Коронавируст халдвар /covid-19/-ын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журмын 8.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /covid-19/-ын голомттой, дэгдэлт гарсан улс эрнөөс ирсэн иргэнийг Сэлэнгэ аймгийн тусгаарлах, ажиглах түр байранд байрласан нэг иргэнд зарцуулагдах өдрийн зардлын хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Тусгаарлах, ажиглах түр байранд байрлах иргэдэд холбогдох хууль, дүрэм журмыг танилцуулж, байрлах хугацааны зардлыг бүрэн төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Онцгой комиссын гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.
3. Тусгаарлах, ажиглах түр байранд байрлах иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлж, эрүүл мэндийн үзлэгийг тухай бүрд нь хийж ажиллахыг аймгийн Онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн  
А/86 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /COVID19/-ЫН ҮЕД  
ТУСГААРЛАХ, АЖИГЛАХ ТҮР БАЙРАН БАЙРЛАХ ИРГЭДИЙН  
НЭГ ӨДРИЙН ЗАРДАЛ

№	Зардлын төрөл	14 хоногт хэрэглэх хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	1 өдрийн зардал
1	Хоолны зардал /Өглөө, өдөр, оройн хоол багтсан/	Өдөр бүр	12,000.0	168,000.0	12,000.0
2	1 удаагийн цагаан хэрэглэл	1ш	30,000.0	30,000.0	2,142.9
3	1 удаагийн хоолны хэрэгсэл	70ш	1,000.0	70,000.0	5,000.0
4	Цэвэр ус /500мл/	14ш	800.0	11,200.0	800.0
5	Хогны уут	14ш	50.0	700.0	50.0
6	Гар ариутгагч /500мл/	1ш	6,000.0	6,000.0	428.6
7	Ариун цэврийн цаас	4ш	1,200.0	4,800.0	342.9
8	Гарын саван	2ш	1,200.0	2,400.0	171.4
9	Нойтон сальфетик /том/	2ш	3,500.0	7,000.0	500.0
10	Цахилгааны хэрэглээ	102.2квт	268.3	27,420.3	1,958.6
11	Халаалтын зардал	4м3	2,166.1	8,664.4	618.9
12	Цэвэр ус	10л	22.7	3,178.0	227.0
13	Бохир ус	15л	40.0	8,400.0	600.0
14	Хог хаягдал устгах зардал	28 удаа	25,000.0	700,000.0	5,000.0
15	Бал	1ш	500.0	500.0	3.6
	<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>			<b>1,047,762.7</b>	<b>29,843.8</b>

0-5 настай хүүхэд 100 хувь чөлөөлөгдөнө

6-16 насны хүүхэд 50 хувь чөлөөлөгдөнө